



2024 он 10 сар 30 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого батлах тухай

Говь ХК-ийн хэмжээнд баримтлах тогтвортой хөгжлийн нэгдсэн стратегийн бодлогыг батлах тухай асуудлыг хэлэлцэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 6.2.7.11 дүгээр заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Говь ХК-ийн “Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.
2. Энэхүү бодлогыг баталсантай холбоотой ТУЗ-ийн 2022 оны 04-р сарын 19-ний өдрийн №11 тоот тогтоолоор баталсан “Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт”-ыг хүчингүйд тооцсугай.
3. Тогтвортой хөгжлийн стратегийн бодлогын хэрэгжилтийг ханган, холбогдох бодлогын баримт бичгүүдэд урт, дунд, богино хугацааны зорилтуудыг тусгаж, олон улсын болон салбарын төрөл бүрийн сайн туршлагуудыг нэвтрүүлэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хянаж, тасралтгүй сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Д.ГЭРЭЛМАА

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-23-01
-------------	---	------------------------

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
1.1 Зорилго	5
1.2 Хамрах хүрээ	5
1.3 Нэр томьёо, товчилсон үгс	5
1.4 Үүрэг хариуцлагын матриц:	6
2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АМЛАЛТ	7
2.1 Тогтвортой хөгжлийн амлалт	7
3. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО	7
3.2 Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны талаарх бодлого	7
3.3 Нийгмийн чиглэлийн бодлого	8
3.4 Ёс зүйтэй засаглалын талаарх бодлого	8
3.5 Тогтвортой хөгжил ба бизнесийн харилцаа	9
3.6 Хэрэглэгчдийн өмнө хүлээх үүрэг	9
3.7 Өртгийн сүлжээ ба зохистой худалдан авалт	9
4. ХЭРЭГЖИЛТ	10
4.1 Хяналт, хэрэгжилт	10

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-23-01
-------------	---	------------------------

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн стратегийн бодлогын зорилго нь байгууллагын Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлс, Нийгмийн хүлээлттэй нийцсэн тогтвортой үйл ажиллагаанд бизнесийг чиглүүлэхэд оршино. Энэхүү стратегийн бодлого нь бизнесийн үйл ажиллагааны шийдвэр гаргалт, стратеги төлөвлөлтийн явцад оролцогч бүхий л талуудыг Тогтвортой хөгжлийн бодлогод нэгтгэх, байгаль орчны менежмент, нийгмийн хариуцлага, ёс зүйтэй засаглалтай холбоотой эрсдэл, боломжуудыг удирдах зорилготой.

1.2 Хамрах хүрээ

- 1.2.1 Энэхүү стратегийн бодлого нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), Гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнууд, охин компаниуд, ханган нийлүүлэгчид болон бусад сонирхогч талуудад хамаарна.
- 1.2.2 Энэхүү баримт бичиг нь НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд болон Даян дэлхийн гэрээний зарчмууд болон Алсын Хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцсэн байх бөгөөд үндсэн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн байна.

1.3 Нэр томьёо, товчилсон үгс

- 1.3.1 **Товчлол:** Баримт бичигт дор дурдсан товчилсон үгийг ашиглаж болно.

- 1.3.1.1 Баримт бичгийн нэрийн товчлол

Хүснэгт 1 Баримт бичгийн нэрийн товчлол

№	Баримт бичгийн нэр	Товчлол
1	Тогтвортой хөгжил	ТХ
2	Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого	ТХСБ

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-23-01
-------------	---	------------------------

1.3.1.2 Албан тушаалын товчлол

Хүснэгт 2 Албан тушаалын товчлол

№	Баримт бичгийн нэр	Товчлол
1	Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ
2	Гүйцэтгэх удирдлага	ГҮ
3	Тогтвортой хөгжлийн хэлтэс	ТХХ
4	Дунд шатны удирдлага	ДШУ

1.4 Үүрэг хариуцлагын матриц:

Хүснэгт 3 Үүрэг хариуцлагын матрицийн хүснэгт

Албан тушаал Процесс	ТУЗ	ГҮ	ТХХ	ДШУ	Ажилтнууд
ТХСБ боловсруулах	3М	3М	ХГ	М	М
ТХСБ батлах	Х	ГЗ	ГЗ	М	М
Бодлогыг нийт ажилтнуудад түгээх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	М	Г	ХГ	Г	М
ТХСБ-г үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	ГЗ	ГЗ	ХГ	ГЗ	Г
Бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах	Г	Г	Х	3М	М
Бодлогын хэрэгжилтэнд хяналт тавих	ГЗ	ГЗ	ХГ	М	М
Шаардлагатай тохиолдолд шинэчлэх	3М	3М	ХГ	3М	М

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-23-01
-------------	---	------------------------

2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АМЛАЛТ

2.1 Тогтвортой хөгжлийн амлалт

- 2.1.1 Говь ХК хариуцлагатай тогтвортой хөгжлийн тогтолцоог бүрдүүлж, хэрэглэгчийн шаардлагыг хангасан чанартай ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ дараах үндсэн чиглэлүүдийг дэмжиж, оролцогч талуудыг чадавхжуулан хамтран ажиллахаа амлаж байна. Үүнд:
 - 2.1.1.1 **Байгаль орчин:** Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг хүлээн зөвшөөрч, компанийн үйл ажиллагааны экологийн ул мөрийг багасгахад онцгой анхаарч, байгалийн нөөцийн хэрэглээг зөв зохистой ашиглах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах арга барилыг хэрэгжүүлэхдэд чиглэн ажиллана.
 - 2.1.1.2 **Нийгмийн хариуцлага:** Хүний эрхийг хүндэтгэсэн, хүртээмжтэй, жендерийн эрх тэгш байдал, оролцоог хангасан ажлын байрыг дэмжиж, нийгэмд эзргээр нөлөөлнө.
 - 2.1.1.3 **Ёс зүйтэй засаглал:** Ил тод, нээлттэй, шударга, хариуцлагатай үйл ажиллагаа явуулж, оролцогч талуудын тэгш оролцоог эрхэмлэн, шударга, ёс зүйтэй шийдвэр гаргах.

3. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО

3.2 Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны талаарх бодлого

- 3.2.1 Бид байгалийн нөөцийг зохистой ашиглан, хог хаягдлыг багасгах, эрчим хүч, усны хэмнэлттэй үйл ажиллагаа, түүхий эдийн хариуцлагатай нийлүүлэлт болон хэрэглээг нэвтрүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах зарчмыг баримтлан хаягдал багатай (circular) эдийн засгийг бүрдүүлэхдэд зорьж ажиллана.
- 3.2.2 Net zero 2050 олон улсын нэгдмэл зорилтын хүрээнд үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрстөрөгч багатай үйлдвэрлэл явуулах, нүүрстөрөгчийн шингээлтийг бий болгох, сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн эрсдэлийг бууруулах арга хэмжээг бүхий л үйл ажиллагаандaa хэрэгжүүлнэ.

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-23-01
-------------	---	------------------------

- 3.2.3 Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа болон хэрэглээг харилцагч, хамтрагч, оролцогч талууд, олон нийтэд уриалан сурталчилна.
- 3.2.4 Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчны менежментийн стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, хэвшүүлж, үйл ажиллагаагаа байнга сайжруулна.

3.3 Нийгмийн чиглэлийн бодлого

- 3.3.1 Бизнес ба хүний эрхийн удирдлагын зарчмууд, олон улсын хүний эрхийн сайн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, нийгмийн нөлөөллөө үнэлж, хүний эрхийг хүндэтгэсэн, жендерийн эрх тэгш байдал, олон талт ялгаатай байдлыг дэмжсэн, ажилтан бүрийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх ижил тэгш боломжийг олгосон, ажлын байрны дарамт, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлэг, албадан хөдөлмөр эрхлэлт, ялгаварлан гадуурхалтгүй байх зохистой ажлын байрыг бий болгохыг зорино.
- 3.3.2 Бид эерэг хандлагатай, бүтээмж, ур чадварт суурилсан чадварлаг баг, хамт олныг бүрдүүлэн, тэдгээрийн гүйцэтгэлийг удирдаж, мэдлэг, чадварыг тасралтгүй сайжруулна.
- 3.3.3 Бид ажилтан, ханган нийлүүлэгч, үйлчлүүлэгч бүрийн эрхийг хүндэтгэн, тэдний аюулгүй байдал болон эрүүл мэндийг эрхэмлэнэ.
- 3.3.4 Нийгмийн хариуцлагын хүрээнд нийгмийн сайн сайхан байдал, амьдрах тавлаг орчин, малчдын амьжиргааг сайжруулахад чиглэсэн санал санаачилгыг дэмжиж, нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлж, бизнесийн тогтвортой, хүртээмжтэй, хариуцлагатай байдлаар оролцогч талууддаа манлайллагч байна.
- 3.3.5 Нуудлийн соёл иргэншилийн биет ба биет бус соёлын өвийг шинжлэн судалж, ирээдүй хойч үедээ түгээн дэлгэрүүлж, өвлүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

3.4 Ёс зүйтэй засаглалын талаарх бодлого

- 3.4.1 Бид компанийн урт хугацааны хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн тасралтгүй байдлыг хангахад удирдлагын зохистой манлайллыг эрхэмлэж, бүхий л оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангасан шударга, ёс зүйтэй, хариуцлагатай засаглалын тогтолцоог бүрдүүлнэ.

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-23-01
-------------	---	------------------------

- 3.4.2 Байгууллагын бүх түвшинд хариуцлагатай, шударга ёсыг дээдэлсэн, мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг эрхэмлэж, хээл хахууль, авлига, ашиг сонирхлын зэрчлөөс ангид хуулийн дагуу үйл ажиллагаа явуулна.

3.5 Тогтвортой хөгжил ба бизнесийн харилцаа

- 3.5.1 Бид зөвхөн хууль тогтоомжийн нийцлийг хангаад зогсохгүй, түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс эхлээд түгээлт, борлуулалт хүртэлх бизнесийн загвартаа Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, зарчмуудыг шингээж, хамтын үнэ цэнэ, дундын экосистем, нээлттэй түншлэл бүхий бизнесээрээ оролцогч талууд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийг бий болгоно.

3.6 Хэрэглэгчдийн өмнө хүлээх үүрэг

- 3.6.1 Бид хэрэглэгчдээ чанартай ноолуурان бүтээгдэхүүнээр хангахаас гадна бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нийгмийн нөхцөл байдал, ёс зүйн хэм хэмжээний талаар ил тод, нээлттэй, хүртээмжтэй мэдээллээр хангаж, зохистой сонголт хийх боломжийг олгоно.
- 3.6.2 Бид бүтээгдэхүүний талаарх байгалийн нөөцийн үр ашигтай хэрэглээ, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон бууруулах, хүний эрх, жендерийн мэдрэмжтэй, тогтвортой худалдан авалт хийх хэрэглэгчдийн мэдлэг, чадавхийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.

3.7 Өртгийн сүлжээ ба зохистой худалдан авалт

- 3.7.1 Бид хүний эрхийг дээдэлсэн, байгаль орчныг хамгаалсан, ёс суртахууны хэм хэмжээг баримталсан, хөдөлмөрийн аюулгүй байдал, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, тогтвортой түүхий эд материал, технологи, үйлчилгээг нийлүүлэх ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллаж, өртгийн сүлжээнд оролцогч талуудын хамтаар хөгжих, тогтвортой хамтын түншлэлийн сүлжээг бий болгоход чиглэн ажиллана.
- 3.7.2 Түүхий эдийн эх үүсвэрээс бүтээгдэхүүн хүртэл мөшгөлтийн тогтолцоог бий болгож олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулж, ханган нийлүүлэлтийн ул мөрийг сайжруулах технологи, системд хөрөнгө оруулалт хийнэ.

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-23-01
-------------	---	------------------------

3.7.3 Үндсэн түүхий эд ноолуурын хувьд тогтвортой, ёс зүйтэй, хариуцлагатай түүхий эдийн эх үүсвэртэй байхыг эрхэмлэж, эх үүсвэрийн нөлөөллийг багасгах зорилгоор бэлчээрийн зөв менежмент бүхий байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхэлдэг ханган нийлүүлэгчдээс худалдан авалт хийнэ . Малчид, ард иргэдийн амьдралыг сайжруулах төрөл бүрийн санал, санаачилгыг дэмжин ажиллана.

4. ХЭРЭГЖИЛТ

4.1 Хяналт, хэрэгжилт

4.1.1 Тогтвортой хөгжлийн стратегийн бодлогын хэрэгжилтийг хангахын тулд холбогдох бодлогын баримт бичгүүдэд урт, дунд, богино хугацааны зорилтуудыг тусгаж, олон улсын болон салбарын төрөл бүрийн сайн туршлагуудыг нэвтрүүлж, хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хянаж, сайжруулах арга хэмжээ авч ажиллана.

ТӨГСӨВ.



20~~24~~ он **10** сар **30** өдөр

Дугаар **37**

Улаанбаатар хот

**Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн
ялгарлыг бууруулах бодлого батлах тухай**

Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн стратегийн бодлогын хүрээнд баримтлах Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлогыг батлах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 6.2.7.11 дүгээр заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- Говь ХК-ийн “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.
- Энэхүү бодлогын хэрэгжилтийг ханган, зорилтод чиглэсэн арга хэмжээг авч, гүйцэтгэлийг хянаж, тасралтгүй сайжруулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Д.ГЭРЭЛМАА

GOBI	ГОВЬ ХК-ИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨНД ДАСАН ЗОХИЦОХ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН БУУРУУЛАХ БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-21-01
-------------	---	------------------------

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
1.1 Зорилго.....	5
1.2 Хамрах хүрээ	5
1.3 Нэр томъёо, товчилсон үг.....	5
1.3 Үүрэг хариуцлагын матриц:.....	6
2. БОДЛОГО.....	7
2.1 Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого	7
3. ЗОРИЛТОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД.....	7
3.1 Хүлэмжийн хийн ялгарлын суурь үнэлгээ хийх	7
3.2 Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах стратеги.....	7
3.3 Хүлэмжийн хийн ялгарлын шингээлтийг нэмэгдүүлэх.....	8
3.4 Технологи ба инновац.....	8
3.5 Оролцогч талуудын оролцоо ба хамтын ажиллагаа.....	8
3.6 Хяналт хийх, мэдээлэх, баталгаажуулах (MRV).....	8
3.7 Бодлогыг хянаж, тасралтгүй сайжруулах	8
4. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	9
4.1 Үүрэг, хариуцлага:.....	9

GOBI	ГОВЬ ХК-ИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨНД ДАСАН ЗОХИЦОХ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН БУУРУУЛАХ БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-21-01
-------------	---	------------------------

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 Говь ХК-ийн уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого нь Net Zero 2050 зорилтод нийцүүлэх, түүнд тэмүүлэхэд оршино.

1.2 Хамрах хүрээ

- 1.2.1 Хамрах хүрээний хувьд үйл ажиллагаанаас үүсэж буй дараах бүх ялгарал багтана. Үүнд:
 - 1.2.1.1 Хамрах хүрээ 1: Шууд ялгаралт;
 - 1.2.1.2 Хамрах хүрээ 2: Худалдан авсан цахилгаан, дулаанаас үүсэх шууд бус ялгаралт;
 - 1.2.1.3 Хамрах хүрээ 3: Нийлүүлэлтийн нинжин хэлхээний дээд болон доод урсгалын үйл ажиллагаа зэргээс үүсэх шууд бус ялгаралт;

1.3 Нэр томъёо, товчилсон үг

- 1.3.1 **Нийлүүлэлтийн гинжин хэлхээ:** Түүхий эд бэлтгэлээс бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгчид хүргэх цогц үйл ажиллагаа
- 1.3.2 **Тогтвортой түүхий ноолуур:** Бэлчээрийн төлөв байдал, малын эрүүл мэнд, мал сүргийн тавлаг байдал, хариуцлагатай малчин, зохистой төлбөр, түүхий эдийн чанар, аюулгүй байдал зэрэг шаардлагыг хангасан түүхий ноолуур;
- 1.3.3 **Тогтвортой хөгжил:** Өнөө үеийн хэрэгцээг хангахдаа ирээдүй үеийн хэрэгцээгээ хангах боломжийг хязгаарлахгүй байх;
- 1.3.4 **Хаягдалгүй эдийн засаг:** Анхнаас нь дахин хэрэглэж болох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, улмаар хэмнэлттэй, үр дүнтэй, ашигтай байх нөхцлийг бүрдүүлэх эдийн засгийн загвар;
- 1.3.5 **Хариуцлагатай татан авалт:** Ханган нийлүүлэгчдийг сонгох, тэдгээрээс худалдан авалт хийх, үйлчилгээ аваходаа байгаль орчин болон нийгэмд ээлтэй нөлөөллийг чухалчлах;
- 1.3.6 **Шууд бус үйл ажиллагаанаас хамаарах хүлэмжийн хий:** Компанийн худалдан авч ашигласан цахилгаан, дулаан, хөргөлт, уурын эрчим хүч мэт;

GOBI	ГОВЬ ХК-ИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨНД ДАСАН ЗОХИЦОХ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН БУУРУУЛАХ БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-21-01
-------------	---	------------------------

1.3.7 **Шууд уйл ажиллагаанаас хамаарах хүлэмжийн хий:** Компанийн ашиглаж байгаа тээврийн хэрэгсэл, станц, машин техник, агааржуулагч, эрчим хүч үүсгүүр гэх мэт;

1.3.1 **Товчлол:** Уг бодлогын хүрээнд дараах товчилсон үгийг ашиглана.

Хүснэгт 1 Товчилсон үгийн тайлбар

№	Товчилсон үгийн тайлбар	Товчилсон үг
1	Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ
2	Гүйцэтгэх захирал	ГЗ
3	Нийцлийн газар	НГ
4	Тогтвортой хөгжлийн хэлтэс	ТХХ
5	Дунд шатны удирдлага	ДШУ

1.3 Үүрэг хариуцлагын матриц:

Хүснэгт 2 Үүрэг хариуцлагын матрицийн хүснэгт

Процесс	Албан тушаал	ТУЗ	ГЗ	МБ	ДШУ	ТХХ	Ажилтнууд
		/Г-гүйцэтгэх,, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэлтэй байх/					
Бодлого боловсруулах		ЗМ	ЗМ	ЗМ	M	Г,Х	-
Бодлого батлах	X	ГЗ	-	-	ГЗ	-	
Бодлогыг нийт ажилтнуудад түгээх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	-	ГЗ	ГЗ	ГЗ	X	M	
Оролцогч талуудад тохиромжтой байдлаар хуртээмжтэй байдлыг хангах	ЗМ	ЗМ	ЗМ	ЗМ	ГХ	ЗМ	
Бодлогыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	ГЗ	ГЗ	ГЗ	ГЗ	ГХ	ГМ	
Бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах	ГЗ	ГЗ	ГЗ	ЗМ	ГХ	M	
Бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх	ГЗМ	ГЗМ	ЗМ	ЗМ	ГХ	M	
Шаардлагатай тохиолдолд шинэчлэх	ГЗМ	ГЗМ	ЗМ	ЗМ	ГХ	M	

11
1A
ЭТ
Х
Л

16
15

GOBI	ГОВЬ ХК-ИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨНД ДАСАН ЗОХИЦОХ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН БУУРУУЛАХ БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-21-01
-------------	---	------------------------

2. БОДЛОГО

2.1 Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого

2.1.1 “Говь” ХК бүхий л үйл ажиллагааныхаа хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, Net Zero түвшинд хүргэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох зорилт тавин ажиллахдаа шинжлэх ухаанд суурилсан зорилтуудыг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчиний хэрэглээг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжин, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасах зохицох арга хэмжээг авч, төрөл бүрийн санал санаачилгуудыг дэмжиж, оролцогч талуудыг мэдлэг мэдээллээр ханганд, чадавхжуулан тогтвортой байдлын төлөө тууштай ажиллах болно.

3. ЗОРИЛТОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

3.1 Хүлэмжийн хийн ялгарлын суурь үнэлгээ хийх

- 3.1.1 Үйл ажиллагаа, үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээн дэх одоогийн хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тодорхойлохын тулд нүүрстөрөгчийн ул мөрийн иж бүрэн шинжилгээ хийх;
- 3.1.2 Мал аж ахуй, үйлдвэрлэл, тээвэрлэлт зэрэг ноолуурын үйлдвэрлэлийн онцлогт тохирсон ялгаралт ихтэй эх үүсвэрүүдийг тодорхойлох;

3.2 Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах стратеги

- 3.2.1 Үйлдвэрлэлд эрчим хүчиний хэмнэлттэй технологийг хэрэгжүүлэх;
- 3.2.2 Үйл ажиллагааны эрчим хүчиний хэрэглээг сэргээгдэх эрчим хүчиний эх үүсвэрт шилжүүлэх;
- 3.2.3 Тогтвортой мал аж ахуйг бий болгох. Бэлчээрийн доройтлыг бууруулж, тогтвортой мал аж ахуй эрхлэх дадлыг нэвтрүүлэхэд малчидтай хамтран ажиллах;
- 3.2.4 Бусад нэмэлт түүхий эдийн хувьд дахин боловсруулсан болон дахин боловсруулах боломжтой материалыг ашиглах;
- 3.2.5 Үйлдвэрлэлийн явцад үүссэн хог хаягдлыг багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах зорилгоор хог хаягдлын менежментийг сайжруулах;

GOBI	ГОВЬ ХК-ИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨНД ДАСАН ЗОХИЦОХ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН БУУРУУЛАХ БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-21-01
-------------	---	------------------------

3.3 Хүлэмжийн хийн ялгарлын шингээлтийг нэмэгдүүлэх

- 3.3.1 Нөхөн сэргээлт, ойжуулалт зэрэг салбартаа хамааралтай нүүрстөрөгчийн хийг нөхөх төслүүдэд хөрөнгө оруулах;
- 3.3.2 Нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэхийн тулд бэлчээрийн талбайн болон орчны ландшафтын менежментийг сайжруулах төслүүдийг дэмжих;

3.4 Технологи ба инновац

- 3.4.1 Ноолуурын үйлдвэрлэлд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх;
- 3.4.2 Цэвэр үйлдвэрлэлийн технологийг судалж, хэрэгжүүлэх;

3.5 Оролцогч талуудын оролцоо ба хамтын ажиллагаа

- 3.5.1 Нийлүүлэгчид, үйлчлүүлэгчид болон орон нутгийн иргэдтэй хамтран хүлэмжийн хийг бууруулах сургалт зохион байгуулах, сурталчлах;
- 3.5.2 Ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн санаачилга, хамтын ажиллагаанд оролцох;

3.6 Хяналт хийх, мэдээлэх, баталгаажуулах (MRV)

- 3.6.1 Ялгарлын бууралт, цэвэр тэг рүү чиглэсэн ахиц дэвшлийг хянахын тулд найдвартай хяналт, тайлагнналын системийг бий болгох;
- 3.6.2 Мэдээллийн ил тод, үнэн зөв, найдвартай байдлыг баталгаажуулах зорилгоор нэр хүнд бүхий, мэргэжлийн гуравдагч этгээдээр хөндлөнгийн аудит хийлгэх ажлыг тухай бүр шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зохион байгуулна.

3.7 Бодлогыг хянаж, тасралтгүй сайжруулах

- 3.7.1 Шинжлэх ухааны шинэ ололт, технологийн дэвшилд дасан зохицох, боловсронгуй болгох чиглэлийг тодорхойлохын тулд бодлого, түүний үр дүнг тогтмол хянаж байх;
- 3.7.2 Шилдэг туршлага, зохицуулалтын шаардлагад нийцүүлэхийн тулд байгаль орчны мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчид болон шинжлэх ухааны нийгэмлэгтэй тасралтгүй яриа хэлэлцээ өрнүүлэх;

GOBI	ГОВЬ ХК-ИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨНД ДАСАН ЗОХИЦОХ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН БУУРУУЛАХ БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-21-01
-------------	---	------------------------

4. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

4.1 Үүрэг, хариуцлага:

- 4.1.1 Говь ХК нь энэхүү бодлогыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хянан байнгын сайжруулах замаар тогтвортой хөгжлийн үүрэг амлалт, энэхүү бодлогын зорилтуудын нийцлийг хангаж ажиллана.
- 4.1.2 Дээд удирдлага нь компанийн стратегийн төлөвлөгөөнд энэхүү бодлого, түүний зорилтуудыг тусгах, бизнесийн үйл явцад нэгтгэх, төлөвлөсөн үр дүнд хүрэх нөхцөлөөр хангана.
- 4.1.3 Дунд шатны удирдлага нь энэхүү бодлого, зорилтыг хэрэгжүүлж, байнгын сайжруулалтыг дэмжих, үр нөлөөтэй байдлыг хангах зорилгоор ажилтнуудын оролцоог хангана.
- 4.1.4 Ажилтан нь компанийн энэхүү бодлого, зорилтуудыг дэмжиж, идэвх санаачилгатай оролцож, хамтран ажиллана.
- 4.1.5 Тогтвортой хөгжлийн хэлтэс нь энэхүү бодлого, зорилтыг боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тасралтгүй сайжруулах үүргийг хүлээнэ. Нийт сонирхогч талуудыг мэдээллээр ханган ажиллана.

ТӨГСӨВ.



20~~24~~ он 10 сар 30 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Хүний эрх, жендерийн бодлого батлах тухай

Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн стратегийн бодлогын хүрээнд баримтлах Хүний эрх, жендерийн бодлогыг батлах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 6.2.7.11 дүгээр заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- Говь ХК-ийн “Хүний эрх, жендерийн бодлого”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.
- Энэхүү бодлогын хэрэгжилтийг ханган, зорилтод чиглэсэн арга хэмжээг авч, гүйцэтгэлийг хянаж, тасралтгүй сайжруулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Д.ГЭРЭЛМАА

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЕРИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-22-01
-------------	---	------------------------

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
1.1 Зорилго.....	5
1.2 Зорилт.....	5
1.3 Хамрах хүрээ	5
1.4 Нэр томъёоны тайлбар	6
1.5 Үүрэг хариуцлагын матриц:.....	7
2. БОДЛОГО, ЗАРЧИМ.....	7
2.1 Хүний эрх, жендерийн бодлого	7
2.2 Хүний эрх, жендерийн үүрэг, амлалт, зарчим	8
3. ЗОРИЛТОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД.....	9
3.1 Манлайлал ба засаглал.....	9
3.2 Хэрэгжилт, хяналтын тогтолцоог бүрдүүлэх.....	9
3.3 Чадавхыг бэхжүүлэх	9
3.4 Хэрэгжилт, хяналт хийх	9
3.5 Үр дүнг тайлагнах, сайжруулах арга хэмжээ.....	10
3.6 Гомдол барагдуулах механизм буюу эргэх холбоо	10
4. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА.....	11
4.1 Үүрэг, хариуцлага:.....	11

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЕРИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-22-01
-------------	---	------------------------

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 Энэхүү бодлогын зорилго нь “Говь” ХК үйл ажиллагаандаа баримтлах хүний эрх, жендерийн бодлого, зорилго, зорилт, зарчмыг тодорхойлох, хүний эрх, жендерийн эрх тэгш байдлын үндсэн зарчмуудыг хангах, хүний эрхийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх тогтолцоог бүрдүүлэгч оролцогч талуудын харилцааг тодорхойлоход оршино.

1.2 Зорилт

- 1.2.1 НҮБ-ЫН Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Бизнес ба хүний эрхийн чиглэлээр НҮБ-ЫН баримтлах удирдах зарчмууд зэрэг олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоонд тулгуурлаж, олон улсын стандарт, Монгол Улсын Үндсэн хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид тусгагдсан хүний эрхийг хүндэтгэх, жендерийн эрх тэгш байдлыг хангах үүрэг амлалтын дагуу ялгаварлан гадуурхахгүй байх, ажилтнуудын эрх, хувийн нууцыг хамгаалах, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлэг болон албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл мэндийг хангах зэрэг хүний эрхийг хүндэтгэх, хүний аливаа эрхийг зөрчихд хувь нэмрээ оруулахгүй байх, үйл ажиллагаа, нийлүүлэлтийн сүлжээнд хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, запруулах идэвхтэй арга хэмжээ авах;
- 1.2.2 Компанийн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлж буй аливаа сөрөг нөлөөллийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, сөрөг нөлөөллөөс үүдэн хүний эрхийн зөрчил гарсан тохиолдолд эрхийг сэргээх зорилгоор хүний эрхийн төлөв байдлаа үнэлэх, арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих, тайлагнах цогц арга хэмжээ бүхий хүний эрхийн магадлан шинжилгээ хийх зэрэг нь энэхүү хүний эрхийн бодлогын зорилт юм.

1.3 Хамрах хүрээ

- 1.3.1. Энэхүү бодлогод байгууллагын нийт ажилтнууд болон ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэл, борлуулалт,

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЕРИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-22-01
-------------	---	------------------------

хэрэглэгч/үйлчлүүлэгч болон өртгийн сүлжээн дэх хэрэглэгч/үйлчлүүлэгч, инноваци, дизайн, хөгжүүлэлт, үйлдвэрлэл, маркетинг, борлуулалт, хэрэглэгчид үйлчлэх зэрэг бүх оролцогч талуудыг хамаарна.

1.4 Нэр томъёоны тайлбар

- 1.4.1 **Хүний эрх:** Хүний эрх нь хүнээс төр, нийгэм, хүмүүстэй харьцах, түүний эдийн засаг, нийгэмшил, улс төр, соёлын хүрээн дэх зан үйлийн боломж юм. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.
- 1.4.2 **Жендер** гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг;
- 1.4.3 **Жендерийн эрх тэгш байдал** гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг;
- 1.4.4 **Хүний эрхийн магадлан шинжилгээ** гэдэг нь бизнесийн байгууллагын үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлж буй ямар нэг сөрөг нөлөөллийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, сөрөг нөлөөллөөс үүдэн хүний эрхийн зөрчил гарсан тохиолдолд эрхийг сэргээх зорилгоор байгууллага хүний эрхийн төлөв байдлаа үнэлүүлэх, арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих, тайлагнах цогц арга хэмжээнүүд юм.
- 1.4.5 **Товчлол:** Уг бодлогын хүрээнд дараах товчилсон үгийг ашиглана.

Хүснэгт 1 Товчилсон үгийн тайлбар

№	Товчилсон үгийн тайлбар	Товчилсон үг
1	Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ
2	Гүйцэтгэх захирал	ГЗ
3	Нийцлийн газар	НГ
4	Тогтвортой хөгжлийн хэлтэс	ТХХ
5	Дунд шатны удирдлага	ДШУ

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЕРИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-22-01
-------------	---	------------------------

1.5 Үүрэг хариуцлагын матриц:

Хүснэгт 2 Үүрэг хариуцлагын матрицийн хүснэгт

Албан тушаал Процесс	ТУЗ	ГЗ	МБ	ДШУ	ТХХ	Ажилтнууд
/Г-гүйцэтгэх,, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэлтэй байх/						
Бодлого боловсруулах	3М	3М	3М	М	Г,Х	-
Бодлого батлах	Х	ГЗ	-	-	ГЗ	-
Бодлогыг нийт ажилтнуудад түгээх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	-	ГЗ	ГЗ	ГЗ	Х	М
Оролцогч талуудад тохиромжтой байдлаар хүртээмжтэй байдлыг хангах	3М	3М	3М	3М	ГХ	3М
Бодлогыг үйл ажиллагаандaa хэрэгжүүлэх	ГЗ	ГЗ	ГЗ	ГЗ	ГХ	ГМ
Бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах	ГЗ	ГЗ	ГЗ	3М	ГХ	М
Бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх	ГЗМ	ГЗМ	3М	3М	ГХ	М
Шаардлагатай тохиолдолд шинэчлэх	ГЗМ	ГЗМ	3М	3М	ГХ	М

2. БОДЛОГО, ЗАРЧИМ

2.1 Хүний эрх, жендерийн бодлого

2.1.1 Энэхүү бодлого нь “Говь” ХК-ийн бизнесийн үйл ажиллагаанд оролцогч талууд болох нийт ажилтнууд, бэлтгэн болон ханган нийлүүлэгчид, гэрээт гүйцэтгэгчид, харилцагчид, хувьцаа эзэмшигчид, орон нутгийн иргэдийн нийгэм болон ёс зүйн үнэт зүйлсийг эрхэмлэн хүндэтгэж, хүний эрх, жендерийн эрх тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг шууд болон шууд бусаар зөрчсөн зан үйлийг үл тэвчин, бизнесийн үйл ажиллагаа, байгууллагын соёлдоо хүний эрхийн үндсэн зарчмуудыг шингээн хэвшүүлж, дээдлэн баримтлахад оршино.

2.2 Хүний эрх, жендерийн үүрэг, амлалт, зарчим

- 2.2.1 Үнэт зүйлийг бий болгох ба хамгаалах Нэгдсэн Үндэстний Байгууллагын Бизнес ба Хүний эрхийн үндсэн зарчмуудын дагуу НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрч, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) хөдөлмөрийн үндсэн стандартууд болон ОУХБ-ын Хөдөлмөрийн үндсэн зарчим ба эрхийн тухай тунхаглал, Хүүхдийн эрхийн конвенцийн зарчмуудыг бизнесийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үүргийнхээ хүрээнд:
- 2.2.1.1 Бид үйл ажиллагаа явуулж буй газар нутагтаа үнэт зүйлсээ эрхэмлэн, хууль тогтоомжийн нийцлийг хангаж дээр дурдсан ёс зүйн хэм хэмжээг чандлан баримтлаж бизнесээ явуулахыг амлаж байна.
- 2.2.1.2 Бүх оролцогч талуудтай харилцахдаа нээлттэй, ил тод, шударга байж, найдвартай, хүртээмжтэй зөвлөлдөх механизмыг бий болгож, харилцан ашигтай хамтын чармайлтыг дээдлэн хамтран ажиллана.
- 2.2.1.3 Бид үндсэн үйл ажиллагаа, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээндээ хүний эрхийг дээдлэж, ялгаварлан гадуурхалтыг үл тэвчин, жендерийн эрх тэгш байдлыг ханган, хөдөлмөрийн мөлжлөгөөс зайлсхийж, дарамт хүчирхийллээс ангид, уян хатан ажлын цагийн зохицуулалттай, эрүүл аюулгүй хөдөлмөр эрхлэх орчинг бүрдүүлэн, хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг дээдлэн, хувийн нууцыг хамгаалан, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хангахын төлөө чармайн ажиллаж, салбартаа жишиг тогтооно.
- 2.2.1.4 Хүний эрхийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх тогтолцоо нь бизнесийн салшгүй хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч хүний эрхэд нөлөөлөх байдлын магадлан шинжилгээг тогтмол хийж хэвшүүлнэ.
- 2.2.1.5 Бизнесийн үйл ажиллагаа болон нийлүүлэлтийн сүлжээний аль ч хэсэгт хүний эрхийн зөрчил, хүчирхийллийг үл зөвшөөрч, компанидаа шүгэл үлээгчийг хамгаалах журмыг хэрэгжүүлж, гомдол барагдуулах механизмаар дамжуулан хүний эрх хөндөгдсөн асуудлыг үр дүнтэйгээр шийдвэрлэнэ.

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЕРИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-22-01
-------------	---	------------------------

3. ЗОРИЛТОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

3.1 Манлайлал ба засаглал

3.1.1 Байгууллагын соёл, удирдлагын зөв манлайлал, үлгэр дуурайлал үзүүлэх зан үйл нь хамт олны хандлага, дадал, зан үйл, хариуцлагыг тодорхойлдог тул хүний эрхийг дээдлэх, олон улсын жишигт нийцүүлэхийн төлөөх компанийн үүрэг амлалтыг тодорхойлж, ТУЗ эрсдэлийн удирдлагын дотоод үйл явцдаа хүний эрхийн асуудлыг авч үзэн, олон улсын жишигт нийцсэн хүний эрхийн цогц бодлогыг боловсруулж, тодорхой асуудал, сорилтуудыг шийдвэрлэхийн тулд холбогдох талуудтай хамтран ажиллана.

3.2 Хэрэгжилт, хяналтын тогтолцоог бүрдүүлэх

3.2.1. Гүйцэтгэх захирал нь Говь ХК-ийн хэмжээнд хүний эрх, жендерийн эрх тэгш байдлын бодлого, зорилго, зорилт, зарчмыг тодорхойлох, хүний эрх, жендерийн тэгш байдлын үндсэн зарчмуудыг хангах, хүний эрхийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх удирдлага, аудит, хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлэх, түүний үр дүнтэй байдал болон хэрэгжилтэд хяналт тавина.

3.3 Чадавхыг бэхжүүлэх

3.3.1. Бизнесийн үйл ажиллагааны хүрээнд нийт ажилтнууд, бэлтгэн нийлүүлэгчид, оролцогч талуудад хүний эрх, жендерийн эрх тэгш байдлын үндсэн зарчмуудыг ойлгуулж, сахин хамгаалах болон байгууллагын холбогдох дүрэм, журам, үйл ажиллагааны талаар хүртээмжтэй сургалт, хүмүүжлийн ажлыг зохион байгуулах нь хүний эрхийг зөрчих эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах үндсэн үйл ажиллагаа тул хүний эрх, жендерийн эрх тэгш байдлын талаар тухайлсан сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

3.3.2. Хүний эрх, жендерийн асуудал хариуцсан гишүүдийг Хүний эрхийн магадлан шинжилгээ (Due Diligence) хийх сургалтанд хамруулж чадавхжуулна.

3.4 Хэрэгжилт, хяналт хийх

3.4.1. Энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагаа болон нийлүүлэлтийн сүлжээн дэх хүний эрх, жендерийн болзошгүй эрсдлийг тодорхойлох, бууруулах зорилгоор Хүний эрхийн магадлан шинжилгээг тогтмол хийнэ.

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЕРИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-22-01
-------------	---	------------------------

3.4.2. Хүний эрхийн магадлан шинжилгээ нь дараах үе шатуудтай байна:

- 3.4.2.1 Хүний эрхийн эрсдэл, сөрөг нөлөөллийг илрүүлэн үнэлэх
 - 3.4.2.2 Хариу арга хэмжээ авах
 - 3.4.2.3 Гүйцэтгэлд хяналт мониторинг хийх
 - 3.4.2.4 Тайлагнан мэдээлэх
- 3.4.3. Хүний эрх, жендерийн магадлан шинжилгээг түргэвчилсэн байдлаар (Rapid test) эсвэл хөндлөнгийн байгууллагатай гэрээ байгуулан хамтарсан магадлан шинжилгээ хийж болно. Хүний эрхийн магадлан шинжилгээний хамрах хүрээ нь дараахь хүний эрхийн нөлөөлөлд өртөж болзошгүй оролцогч талуудаар тодорхойлогоно:
- 3.4.3.1 Байгууллагын үндсэн ба гэрээт ажилтанууд
 - 3.4.3.2 Гэрээт гүйцэтгэгчид, тэдгээрийн ажилтанууд
 - 3.4.3.3 Бэлтгэн нийлүүлэгчид, тэдгээрийн туслан гүйцэтгэгчид
 - 3.4.3.4 Үйлчлүүлэгчид, хэрэглэгчиддхг,
 - 3.4.3.5 Орон нутгийн иргэд
 - 3.4.3.6 Байгаль орчны сөрөг нөлөөлөл нь хүний эрхийн асуудал болох

3.5 Үр дүнг тайлагнах, сайжруулах арга хэмжээ

- 3.5.1 Хүний эрх, жендерийн магадлан шинжилгээний үр дүнд Залруулах арга хэмжээний (Corrective action plan) төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлнэ. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 6 сар тутамд нэг удаа явцын хяналт, мониторинг хийнэ. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.
- 3.5.2 Хүний эрхийн талаарх шинээр гарч буй хууль тогтоомж, олон улсын шилдэг туршлага байнга хувьсан өөрчлөгдөж байдаг тул хүний эрхийн эрсдлийн үнэлгээг жил тутам хийж, улс орны болон олон улсын чиг хандлагатай уялдуулан эрсдлийн удирдлагын тогтолцоогоо байнга сайжруулна.

3.6 Гомдол барагдуулах механизм буюу эргэх холбоо

- 3.6.1 Говь ХК-ийн Хүний эрх, Жендерийн эрхийн зөрчилтэй холбоотой гомдол барагдуулах системийг тогтмол ажиллуулж, гомдлыг барагдуулж, сайжруулах үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 3.6.2 Оролцогч талуудын хүний эрхийн сөрөг нөлөөллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд татан

GOBI	ГОВЬ ХК-ИЙН ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЕРИЙН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-22-01
-------------	---	------------------------

оролцуулах гол хөшүүрэг нь гомдол барагдуулах механизмын хүртээмж, найдвартай байдал учир гомдол барагдуулах механизмынхаа хамрах хүрээ, ойлголт, хүртээмжийг сайжруулахад түлхүү анхааран ажиллана.

4. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

4.1 Үүрэг, хариуцлага:

- 4.1.1 Говь ХК нь энэхүү бодлогыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хянан байнгын сайжруулах замаар тогтвортой хөгжлийн үүрэг амлалт, энэхүү бодлогын зорилтуудын нийцлийг хангаж ажиллана.
- 4.1.2 Дээд удирдлага нь компанийн стратегийн төлөвлөгөөнд энэхүү бодлого, түүний зорилтуудыг тусгах, бизнесийн үйл явцад нэгтгэх, төлөвлөсөн үр дүнд хүрэх нөхцөлөөр хангана.
- 4.1.3 Дунд шатны удирдлага нь энэхүү бодлого, зорилтыг хэрэгжүүлж, байнгын сайжруулалтыг дэмжих, үр нөлөөтэй байдлыг хангах зорилгоор ажилтнуудын оролцоог хангана.
- 4.1.4 Ажилтан нь компанийн энэхүү бодлого, зорилтуудыг дэмжиж, идэвх санаачилгатай оролцож, хамтран ажиллана.
- 4.1.5 Тогтвортой хөгжлийн хэлтэс нь энэхүү бодлого, зорилтыг боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тасралтгүй сайжруулах үүргийг хүлээнэ. Нийт сонирхогч талуудыг мэдээллээр ханган ажиллана.

ТӨГСӨВ.



20~~24~~ он 10 сар 30 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Нийгмийн хариуцлагын бодлого батлах тухай

Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн стратегийн бодлогын хүрээнд баримтлах Нийгмийн хариуцлагын бодлогыг батлах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 6.2.7.11 дүгээр заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- Говь ХК-ийн “Нийгмиин хариуцлагын бодлого”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.
- Энэхүү бодлогын хэрэгжилтийг ханган, зорилтод чиглэсэн арга хэмжээг авч, гүйцэтгэлийг хянаж, тасралтгүй сайжруулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Д.ГЭРЭЛМАА

GOBI	ГОВЬ ХК-ИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-20-01
-------------	---	------------------------

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
1.1 Зорилго.....	5
1.2 Хамрах хүрээ	5
1.3 Нэр томьёо, товчилсон үг.....	5
1.3 Үүрэг хариуцлагын матриц:.....	6
2. БОДЛОГО	6
2.1 Нийгмийн хариуцлагын бодлого	6
3. ЗОРИЛТОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД.....	7
3.1 Зорилтод чиглэсэн арга хэмжээнүүд.....	7
3.2 Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих чиглэлд.....	7
3.3 Малын тавлаг байдлыг хангах чиглэлд	7
3.4 Ажилчдын тав тухтай байдлыг хангах чиглэлд.....	7
3.5 Олон нийтийг чадавхжуулах чиглэлд.....	7
3.6 Хэрэглэгчийн мэдлэг, оролцоо нэмэгдүүлэх чиглэлд.....	8
3.7 Байгаль орчныг хамгаалах чиглэлд	8
4. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	9
4.1 Үүрэг, хариуцлага:.....	9
5. ХЯНАЛТ БА ТАЙЛАГНАЛ	9
5.1 Хяналт ба тайлagnal:.....	9

GOBI	ГОВЬ ХК-ИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-20-01
-------------	---	------------------------

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 Байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд нийгмийн сайн сайхан байдлыг сайжруулахад чиглэгдсэн санал, санаачилгыг дэмжих үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Хамрах хүрээ

1.2.1 Энэхүү бодлого нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөл, нийт ажилтнууд, охин компанийн ажилтнууд, гэрээт компани, ханган нийлүүлэгч болон бусад оролцогч талуудад хамаарна.

1.3 Нэр томъёо, товчилсон үг

1.3.1 **Компанийн нийгмийн хариуцлага:** Оролцогч талуудын ашиг сонирхлыг ухамсарлан эдийн засаг, нийгэм, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахын тулд байгууллагын хэрэгжүүлж буй ашгийн бус арга хэмжээ

1.3.2 **Товчлол:** Уг бодлогын хүрээнд дараах товчилсон үгийг ашиглана.

Хүснэгт 1 Товчилсон үгийн тайлбар

№	Товчилсон үгийн тайлбар	Товчилсон үг
1	Компанийн нийгмийн хариуцлага	КНХ
2	Төлөөлөн удирдах зөвлөл	ТҮЗ
3	Гүйцэтгэх захирал	ГЗ
4	Нийцлийн газар	НГ
5	Тогтвортой хөгжлийн хэлтэс	ТХХ
6	Дунд шатны удирдлага	ДШУ

GOBI	ГОВЬ ХК-ИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-20-01
-------------	---	------------------------

1.3 Үүрэг хариуцлагын матриц:

Хүснэгт 2 Үүрэг хариуцлагын матрицийн хүснэгт

Процесс	Албан тушаал	ТУЗ	ГЗ	МБ	ДШУ	ТХХ	Ажилтнууд
/Г-гүйцэтгэх, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэлтэй байх/							
Бодлого боловсруулах	3М	3М	3М	М	Г,Х	-	
Бодлого батлах	Х	ГЗ	-	-	ГЗ	-	
Бодлогыг нийт ажилтнуудад түгээх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	-	ГЗ	ГЗ	ГЗ	Х	М	
Оролцогч талуудад тохиромжтой байдлаар хүртээмжтэй байдлыг хангах	3М	3М	3М	3М	ГХ	3М	
Бодлогыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	ГЗ	ГЗ	ГЗ	ГЗ	ГХ	ГМ	
Бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах	ГЗ	ГЗ	ГЗ	3М	ГХ	М	
Бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх	ГЗМ	ГЗМ	3М	3М	ГХ	М	
Шаардлагатай тохиолдолд шинэчлэх	ГЗМ	ГЗМ	3М	3М	ГХ	М	

2. БОДЛОГО

2.1 Нийгмийн хариуцлагын бодлого

2.1.1 Говь ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд нийгмийн сайн сайхан байдал, амьдрах тавлаг орчин, малчдын амьжиргааг сайжруулахад чиглэсэн санал санаачилгыг дэмжиж, нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлж, бизнесийн тогтвортой, хүртээмжтэй, хариуцлагатай байдлаар оролцогч талууддаа манлайлагч болж ажиллана.

GOBI	ГОВЬ ХК-ИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-20-01
-------------	---	------------------------

3. ЗОРИЛТОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

3.1 Зорилтод чиглэсэн арга хэмжээнүүд

3.1.1 Говь ХК нь бизнесээ хариуцлагатай, ёс зүйтэй явуулахыг эрмэлзэх бөгөөд ажилтнууд, ханган нийлүүлэгчид, үйлчлүүлэгчид болон хүрээлэн буй орчны өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлаж, ноолуур боловсруулах үйл ажиллагааныхаа бүх шатанд зөв дадлыг нэвтрүүлэхийг эрмэлзэж дараах үйл ажиллагаануудыг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжин ажиллах болно.

3.2 Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих чиглэлд

- 3.2.1 Нүүдлийн мал аж ахуйг дэмжин, түүхий эд бэлтгэгч малчдыг урамшуулж, тэдний уламжлалт амьжиргааг тогтвортой байлгахын зэрэгцээ бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулах арга хэмжээ;
- 3.2.2 Малчдын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, ноолуурын чанарыг сайжруулахын тулд тогтвортой мал аж ахуй, зохистой бэлчээрийн дадлагын талаар боловсрол олгох арга хэмжээ;

3.3 Малын тавлаг байдлыг хангах чиглэлд

- 3.3.1 Мал амьтанд хүнлэг байдлаар хандаж, мал амьтанд хор хөнөөлгүй зохистой тэжээлээр хангах, мал эмнэлийн тусламж үйлчилгээнд тогтмол хамруулах, ноосыг хяргах, ноолуурыг самнах үйл ажиллагааг технологийн дагуу хийх арга хэмжээ;

3.4 Ажилтнуудын тав тухтай байдлыг хангах чиглэлд

- 3.4.1 Бүх ажилтнуудад аюулгүй ажиллах нөхцөл, нийцэмжит цалин хөлс, мэргэжлийн өсөлтийг хангах боломжийг олгох арга хэмжээ;
- 3.4.2 Жендерийн эрх тэгш байдлыг дэмжиж, эмзэг бүлэг болон нийгмийн цөөнхөд хамаарах иргэдэд шударга, эрх тэгш, үл ялгavarлах, хүртээмжтэй, хүсэмжит ажлын байр бий болгох арга хэмжээ;

3.5 Олон нийтийг чадавхжуулах чиглэлд

- 3.5.1 Малчин өрх, олон нийт, нийгмийн эмзэг бүлэг /тухайлбал тусгай хэрэгцээт иргэн, өндөр настан, эмэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэй, эрэгтэй хүмүүс зэрэг/-ийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх дадал зуршлыг бий болгох, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, иргэдийг боловсролын дээшлүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ;

GOBI	ГОВЬ ХК-ИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-20-01
-------------	---	------------------------

3.5.2 Дэд бүтцийн хөгжил: Орон нутгийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх, тухайлбал, цэвэр усны эх үүсвэр болон ариун цэврийн байгууламжийг бий болгох, сэргээх, сэргээгдэх эрчим хүчиний хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээ;

3.6 Хэрэглэгчийн мэдлэг, оролцоо нэмэгдүүлэх чиглэлд

- 3.6.1 Тогтвортой бүтээгдэхүүний боловсрол олгох, хэрэглэгчдэд ноолууран бүтээгдэхүүний тогтвортой байдал, ашиглалтын хугацааг уртасгахын тулд хэрхэн арчлах, ёс зүйтэй брэндүүдийг дэмжихийн ач тусын талаар тодорхой мэдээлэл өгөх арга хэмжээ;
- 3.6.2 Хэрэглэгчдэд зориулж хуучин ноолууран хувцсаа дахин боловсруулах, буцаах хөтөлбөрийг боловсруулж, хог хаягдлыг багасгаж, тойрог эдийн засгийг дэмжих арга хэмжээ;

3.7 Байгаль орчныг хамгаалах чиглэлд

- 3.7.1 Монголын ноолуурын салбарт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, Бэлчээрийг даацыг бууруулах, нөхөн сэргээх төслүүд, биологийн олон янз байдал, эрүүл экосистемийг дэмжих чиглэлээр орон нутгийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах арга хэмжээ;
- 3.7.2 Үйлдвэрлэлд байгальд ээлтэй дэвшилтэт технологийг судалж үйл ажиллагааны туршид түүхий эд, материалыг дахин боловсруулах, дахин ашиглахыг дэмжих замаар хог хаягдлыг хэмжээг бууруулж, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжиж ажиллана;
- 3.7.3 Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл эрхлэхийн тулд усны хэрэглээ бууруулах, химийн хортой болон аюултай бодисын хэрэглээг багасгах, шинэ технологийг хөгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, үйлдвэрлэлд хог хаягдлыг бууруулах зэрэг тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ;
- 3.7.4 Нүүрстөрөгчийн хийг бууруулахын тулд түүхий ноолуурын эх үүсвэрээс эцсийн бүтээгдэхүүн хүргэх хүртэл нийлүүлэлтийн сүлжээгээр нүүрстөрөгчийн ялгаралтыг хянаж, бууруулах арга хэмжээ;

GOBI	ГОВЬ ХК-ИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО	Дугаар: Б-ТХХ-20-01
-------------	---	------------------------

4. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ БА ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

4.1 Үүрэг, хариуцлага:

- 4.1.1 Говь ХК нь энэхүү бодлогыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хянан байнгын сайжруулах замаар тогтвортой хөгжлийн үүрэг амлалт, энэхүү бодлогын зорилтуудын нийцлийг хангаж ажиллана.
- 4.1.2 Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ байгууллагын санхүүгийн болон хүний нөөцийн боломжид тулгуурлан зохистой төлөвлөх бөгөөд үйл ажиллагааныхаа нөлөөллийг бууруулах чиглэлийг нэн тэргүүнд тавина.
- 4.1.3 Дээд удирдлага нь компанийн стратегийн төлөвлөгөөнд энэхүү бодлого, түүний зорилтуудыг тусгах, бизнесийн үйл явцад нэгтгэх, төлөвлөсөн үр дүнд хүрэх нөхцөлөөр хангана.
- 4.1.4 Дунд шатны удирдлага нь энэхүү бодлого, зорилтыг хэрэгжүүлж, байнгын сайжруулалтыг дэмжих, үр нөлөөтэй байдлыг хангах зорилгоор ажилтнуудын оролцоог хангана.
- 4.1.5 Ажилтан нь компанийн энэхүү бодлого, зорилтуудыг дэмжиж, идэвх санаачилгатай оролцож, хамтран ажиллана.
- 4.1.6 Тогтвортой хөгжлийн хэлтэс нь энэхүү бодлого, зорилтыг боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тасралтгүй сайжруулах үүргийг хүлээнэ. Нийт сонирхогч талуудыг мэдээллээр ханган ажиллана.

5. ХЯНАЛТ БА ТАЙЛАГНАЛ

5.1 Хяналт ба тайлагнал:

- 5.1.1 Байгаль орчны өнөөгийн стандарт, нийгмийн хүлээлттэй нийцүүлэхийн тулд 2 жил тутам нийгмийн хариуцлагын талаарх санал санаачилгуудаа тогтмол хянаж, шинэчилнэ.
- 5.1.2 Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаа, ахиц дэвшлийн талаар албан ёсны вэб сайт болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан оролцогч талуудад жил бүр тайлагнана.

ТӨГСӨВ.



20~~24~~ он ~~10~~ сар ~~30~~ өдөр

Дугаар ~~№~~

Улаанбаатар хот

Комплайнсын бодлого шинэчлэн батлах тухай

Говь ХК-ийн хэмжээнд комплайнсын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, үйл ажиллагаатай уялдуулан сайжруулах зорилгоор Комплайнсын бодлогыг шинэчлэн батлах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 6.2.7.11 дүгээр заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

- Говь ХК-ийн “Комплайнсын бодлого”-ыг Хавсралт-1 ёсоор шинэчлэн баталсугай.
- Энэхүү бодлогыг шинэчлэн баталсантай холбоотой Гүйцэтгэх захирлын 2022 оны 05-р сарын 02-ны өдрийн А/187 тоот тушаалаар баталсан “Комплайнсын бодлого”-ыг хүчингүйд тооцсугай.
- Шинэчлэн батлагдсан бодлогын хэрэгжилтийг ханган, зорилтод чиглэсэн арга хэмжээг авч, гүйцэтгэлийг хянаж, тасралтгүй сайжруулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.



GOBI	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЙНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-02
-------------	------------------------------------	--------------------------

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
1.1 Зорилго.....	5
1.2 Хамрах хүрээ	5
1.3 Нэр томьёо, товчилсон үг.....	5
1.4 Үүрэг хариуцлагын матриц:.....	7
2. ЗОРИЛТ, ЗАРЧИМ	8
2.1 Комплайнсын зорилт	8
2.2 Зарчим	8
3. КОМПЛАЙНСЫН ЧИГ ҮҮРЭГ	9
3.1 ТУЗ-ийн чиг үүрэг.....	9
3.2 Гүйцэтгэх захирлын чиг үүрэг	9
3.3 Дотоод аудитын чиг үүрэг.....	9
3.4 Санхүүгийн нэгжийн чиг үүрэг.....	9
3.5 Нийцлийн газрын чиг үүрэг.....	10
3.6 Байгууллагын бусад газар нэгжийн чиг үүрэг.....	11
4. КОМПЛАЙНСЫН БИЕ ДААСАН БАЙДАЛ	12
4.1 Бие даасан байдал:	12
5. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	13
5.1 Комплайнсын бодлогын үүрэг, хариуцлага.....	13

GOBI	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЙНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-02
-------------	------------------------------------	--------------------------

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

- 1.1.1 Комплайнсын шаардлага болон үүрэг, амлалтыг чанд мөрдөн, байгууллагын үнэт зүйл, ёс зүйн хэм хэмжээг хариуцлагатай зан үйл болгон төлөвшүүлж, комплайнсын эрсдэлийг удирдан, ёс зүйтэйгээр үйл ажиллагаа явуулахад энэхүү бодлогын зорилго оршино.
- 1.1.2 Байгууллага нь зарим чиг үүргээ гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх тохиолдолд гуравдагч этгээд нь энэхүү бодлогын холбогдох шаардлагыг хангасан байна.

1.2 Хамрах хүрээ

- 1.2.1 Энэхүү бодлого нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд Говь ХК-ийн /цаашид байгууллага гэх/ нийт ажилтнууд, охин компанийн ажилтнууд, гэрээт компани, ханган нийлүүлэгч болон хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж буй ажилтнууд, комплайнсын шаардлага болон үүрэг амлалтад үйл ажиллагааг нийцүүлэн, бизнесийн болон ажилтны ёс зүйг эрхэмлэн ажиллахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн удирдлагын дээд бичиг баримт байна.

1.3 Нэр томъёо, товчилсон үг

- 1.3.1 **Комплайнсын үйл ажиллагаа:** Байгууллагын дотоодод мөрдөгдөх дүрэм, журам, заавар, зааварчилгаа болон үйл ажиллагаа нь Олон улсын стандарт, Монгол Улсын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шаардлага, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны хэм хэмжээнд нийцэж байгаа байдалд хяналт тавих, нийцүүлэх үйл ажиллагаа;
- 1.3.2 **Комплайнсын эрсдэл:** Байгууллага дотоодод мөрдөгдөх дүрэм, журам, заавар, зааварчилгаа болон үйл ажиллагаа нь Олон улсын стандарт, Монгол Улсын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шаардлага, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны хэм хэмжээг мөрдөж ажиллаагүйн улмаас хуулийн хариуцлага, эрх бүхий байгууллагын торгууль, шийтгэл хүлээх, санхүүгийн бодит алдагдалд орох, нэр хүндийн эрсдэл хүлээх, нийгэм болон хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхэд хүргэж болзошгүй сөрөг нөхцөл байдал;

- 1.3.3 **Комплайнсын нэгж:** Комплайнсын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, бууруулах үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах ажлын хүрээнд ГЗ-д дэмжлэг үзүүлэх, холбогдох асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах үндсэн нэгж;
- 1.3.4 **Комплайнсын шаардлага:** Байгууллага зайлшгүй дагаж мөрдвөл зохих аливаа үүрэг, шаардлага;
- 1.3.5 **Комплайнсын үүрэг амлалт:** Байгууллага дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн аливаа үүрэг, амлалт;
- 1.3.6 **Комплайнсын соёл:** Байгууллагын комплайнсын зан үйл нь хяналтын тогтолцоо, бүтэц зохион байгуулалттай харилцан үйлчилснээр бий болдог үнэт зүйлс, ёс зүй, итгэл үнэмшил;
- 1.3.7 **Удирдлагын тогтолцоо:** Байгууллагын харилцан уялдаа холбоо эсвэл харилцан нөлөөллийг бүрдүүлэх зорилгодоо хүрэхэд чиглэсэн үйл явцын цогц;
- 1.3.8 **Бодлого:** Байгууллагын баримтлах ерөнхий чиглэл, зорилго, зарчмыг тодорхойлж буй удирдлагын дээд баримт бичиг;
- 1.3.9 **Эрх бүхий байгууллага:** Хуулиар эрх олгогдсон төрийн захиргааны болон тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллага.

Хүснэгт 1 Товчилсон үгийн тайлбар

№	Товчилсон үгийн тайлбар	Товчилсон үг
1	Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ
2	Гүйцэтгэх захирал	ГЗ
3	Нийцлийн газар	НГ
4	Дунд шатны удирдлага	ДШУ

GOBI

ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЙНСЫН
БОДЛОГО

Дугаар:

Б22-ТХХ-01-02

1.4 Үүрэг хариуцлагын матриц:

Хүснэгт 2 Үүрэг хариуцлагын матрицийн хүснэгт

Албан тушаал Процесс	ТУЗ	ГЗ	НГ	ДШУ	Ажилтнууд
<i>/Г-гүйцэтгэх,, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэлтэй байх/</i>					
Комплийнсын бодлогыг боловсруулах	3	3Г	ГХ	M	
Комплийнсын бодлогыг батлах	ГХ	3Г	3Г		
Комплийнсын бодлогыг нийт ажилтнуудад түгээх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх		3Г	ГХ	M	M
Оролцогч тохиромжтой байдлаар хүртээмжтэй байдлыг хангах		3Г	ГХ	3Г	
Комплийнсын бодлогыг үйл ажиллагаандaa хэрэгжүүлэх	ГМ	ГХ	Г	Г	МГ
Комплийнсын бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах		3Г	ГХ	M	M
Шаардлагатай тохиолдолд шинэчлэх	3Г	3Г	ГХ	M	

GOBI	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЙНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-02
-------------	------------------------------------	--------------------------

2. ЗОРИЛТ, ЗАРЧИМ

2.1 Комплайнсын зорилт

- 2.1.1 Комплайнсын холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгон тэдгээрийг нийт ажилтнуудад түгээх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрх үүрэгт нь тусган өгөх, байнгын идэвхжүүлэлт хийх замаар байгууллагын соёлыг бүрдүүлж, комплайнсын шаардлага болон үүрэг амлалтыг мөрдөн комплайнсын эрсдэлийг бууруулж “ЗӨРЧИЛ=0” байх зорилгын төлөө ажиллана. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:
- 2.1.1.1 Ёс зүйн хэм хэмжээ: Говь ХК-ийн үнэт зүйлсийг тулгуур зарчим болгон баримталж, бизнесийн үйл ажиллагааг шударга, ёс зүйтэй явуулж, ёс зүйн зөрчлийг бүрэн хүлээн авч шийдвэрлэн, хэрэгжилтийг хангуулж ажиллах;
 - 2.1.1.2 Комплайнсын шаардлага болон үүрэг амлалт: Комплайнсын шаардлага болон үүрэг амлалтыг үйл ажиллагаандаа нийцүүлэн, ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулж, хуулийн хариуцлага хүлээх болон санхүүгийн алдагдалгүй ажиллах;
 - 2.1.1.3 Комплайнсын эрсдэлийн менежмент: Учирч болзошгүй комплайнсын эрсдэлийг урьдчилан тодорхойлох, үнэлгээ хийх, дүгнэх, удирдах, мониторингийг тасралтгүй хийж, комплайнсын эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах;
 - 2.1.1.4 Авлига, ашиг сонирхлоос анgid хуулийн хүрээнд ажиллах: Нийт оролцогч талууд авлига ашиг сонирхлын зөрчлөөс анgid байх.

2.2 Зарчим

- 2.2.1 Бид бүхий л үйл ажиллагаандаа шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан ажиллана.
- 2.2.2 Ажилтнуудын санал санаачилга, оролцоог нэмэгдүүлэн үл буруутгах зарчмыг баримтлан, тогтолцоог сайжруулан ажиллана.
- 2.2.3 Бид аливаа харилцаанд эрх тэгш, найрсаг, хүндэтгэлтэй байх зарчмыг баримтлан ажиллана.
- 2.2.4 Байгууллагын ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх зарчмыг баримтлан ажиллана.
- 2.2.5 Бид НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудыг баримтлан ажиллана.

GOBI	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЙНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-02
-------------	------------------------------------	--------------------------

- 2.2.6 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг бүрэн удирдаж, нийт ажилтнуудын ХЭМАБ-н мэдлэг, чадамжийг тасралтгүй сайжруулах замаар оролцогч талуудын аюулгүй байдлыг хангана.
- 2.2.7 Байгууллага нь комплайнсын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан журмыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, мөрдүүлнэ.

3. КОМПЛАЙНСЫН ЧИГ ҮҮРЭГ

3.1 ТУЗ-ийн чиг үүрэг

3.1.1 ТУЗ нь энэхүү бодлогыг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.2 Гүйцэтгэх захирлын чиг үүрэг

3.2.1 ГЗ нь ТУЗ-с баталсан комплайнсын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох дүрэм, журмыг батлах, байгууллагын нийт ажилтнуудад хүргэж мөрдүүлэх, үлгэр дууриалал үзүүлэх, аливаа зөрчил дутагдлыг засаж запруулах, буруутай этгээдэд тухай бүр хариуцлага хүлээлгэх үүрэг хүлээж, байгууллагын хэмжээнд комплайнсын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

3.2.2 ГЗ нь НГ-ын ажилтан, удирдлагын албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадварыг тогтмол ахиулахад анхаарах бөгөөд, мэдлэг ур чадвараа нэмэгдүүлэх, холбогдох сургалт, уулзалт, зөвлөгөөнд хамрагдах нөхцөл, бололцоогоор хангана.

3.3 Дотоод аудитын чиг үүрэг

3.3.1 НГ нь энэхүү бодлогод заасан болон холбогдох дүрэм, журамд заасны дагуу комплайнсын эрсдэлийг үр дүнтэй удирдаж байгаа эсэх болон Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээтэй холбоотой хяналтыг хэрэгжүүлж буй байдалд Дотоод аудитын нэгжээс хяналт тавьж ТУЗ-д тайлagnana.

3.3.2 Дотоод аудитын нэгж болон комплайнсын чиг үүрэг бүхий нэгж нь тус тусын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад олж ирүүлсэн зөрчил дутагдлын талаар харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллана.

3.4 Санхүүгийн нэгжийн чиг үүрэг

3.4.1 Байгууллагын Санхүүгийн нэгж нь аливаа гүйлгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт

GOBI	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЙНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-02
-------------	------------------------------------	--------------------------

хэрэгтэй холбоотой гэж сэжиглэсэн эсвэл Нэгдсэн Үндэстний Байгууллага болон эрх бүхий байгууллагаас баталсан санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний жагсаалтад орсон харилцагч байж болзошгүй гэж үзсэн болон холбогдох журмаар тогтоосон босго дүнгээс дээш үнийн дүн бүхий гүйлгээний талаарх мэдээллийг нэн даруй НГ-т хүргүүлж ажиллана.

3.4.2 НГ-т мэдэгдэх шаардлагатай босго үнийн дүн болон мэдээлэл хүргүүлэх хэлбэрийг НГ-ын санал болгосноор ГЗ-ын тушаалаар баталж, мөрдүүлнэ.

3.5 Нийцлийн газрын чиг үүрэг

3.5.1 НГ нь комплайнсын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, бууруулах үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах ажлын хүрээнд ГЗ-д дэмжлэг үзүүлэх, холбогдох асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах үндсэн нэгж байна.

3.5.2 НГ нь комплайнсын бодлого боловсруулах, байгууллагат учирч болох хянан нийцүүлэлтийн эрсдэлийг үр дүнтэй удирдахад ГЗ-г дэмжин ажиллах үүрэгтэй.

3.5.3 НГ нь комплайнсын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, орчин үеийн чиг хандлагын талаар ГЗ, холбогдох нэгж, ажилтанд зөвлөх үүрэгтэй.

3.5.4 НГ нь ГЗ-д байгууллагын ажилтнуудыг комплайнсын эрсдэлийн чиглэлээр сургах, заавар, зөвлөмж боловсруулах, мэдлэг олгоход туслах бөгөөд уг асуудлаар мэдээлэл, лавлагаа өгөх үүрэгтэй үндсэн нэгж байна.

3.5.5 НГ нь байгууллагын үйл ажиллагаанд учирч болох комплайнсын эрсдэлийг тодорхойлох, тэдгээрийг үнэлэх, баримтжуулан нэгдсэн бүртгэл хөтлөх үүрэгтэй.

3.5.6 НГ нь байгууллагын комплайнсын үйл ажиллагааны журмын үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавих бөгөөд аливаа дутагдал илрүүлсэн тохиолдолд өөрчлөлт оруулах саналаа ГЗ-д хүргэх үүрэгтэй.

3.5.7 Байгууллагын нэгжийн удирдлагууд нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль, эрх зүйн акт, дотоод дүрэм, журам, ёс зүйн хэм хэмжээг зохих ёсоор мөрдүүлж ажиллаж байгаа эсэхэд НГ хяналт тавьж ажиллана.

3.5.8 Байгууллагын газар, хэлтэс, нэгжүүд нь хууль, эрх зүйн акт, стандарт, дотоод дүрэм, журам, ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллаж байгаа эсэхийг шалгах зорилгоор НГ-аас жилд нэгээс доошгүй удаа шалгалт, сорил зохион байгуулж үр дүнг ГЗ-д танилцуулна.

GOBI	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЙНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-02
-------------	------------------------------------	--------------------------

- 3.5.9 НГ нь байгууллагын комплайнсын нөхцөл байдал, эрсдэл, илрүүлсэн зөрчил дутагдал болон засаж сайжруулах шаардлагатай асуудлаар танилцуулга боловсруулж холбогдох нэгж болон ГЗ-д танилцуулна.
- 3.5.10 НГ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргээс байгууллагын хэмжээнд урьдчилан сэргийлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл болон эрх бүхий байгууллагын хориг арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээнэ.
- 3.5.11 НГ нь байгууллагын хэмжээнд залилан, луйвар, ашиглангаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг хариуцан зохион байгуулах бөгөөд холбогдох журмыг боловсруулан ГЗ-р батлуулж түүнд хяналт тавьж ажиллана.
- 3.5.12 НГ нь комплайнсын чиглэлээр бусад байгууллага, сонирхогч этгээдтэй хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 3.5.13 НГ нь Шүгэл үлээх тогтолцоо, мэдээлэл хүлээн авах сувгийг нууцлал, аюулгүй байдал бүрэн хангагдсан, үр дүнтэй, хэрэгжүүлэх үүргийг хүлээх бөгөөд холбогдох дүрэм, журмыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж мөрдүүлнэ.
- 3.5.14 НГ нь байгууллагын хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 3.5.15 Комплайнсын бодлогын хэрэгжилт, үр дүн болон бодлогод өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар ГЗ нь НГ-тай хамтран ТУЗ-д тайлагнан ажиллана.
- 3.5.16 НГ нь энэхүү журмын 3.4.2 дэх хэсэгт заасны дагуу ирсэн мэдээллийг нягтлах үүрэг хүлээх бөгөөд гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй эсвэл хориг арга хэмжээний жагсаалтад орсон этгээдтэй холбоотой байна гэж үзвэл тухайн гүйлгээг нэн даруй зогсоох чиглэлийг өгч эрх бүхий байгууллагад хууль болон холбогдох дүрэм, журамд заасан хугацаанд, тогтоосон шаардлагын дагуу мэдээлэх үүрэг хүлээнэ.

3.6 Байгууллагын бусад газар, нэгжийн чиг үүрэг

- 3.6.1 Байгууллагын бусад газар нэгж нь өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн акт, стандарт, түүнд орсон өөрчлөлтүүдийн талаар тогтмол судалж мэдэх, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд хэрэгжилтэд НГ хяналт тавина.
- 3.6.2 Байгууллагын бусад газар нэгж нь өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд комплайнсын эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй бөгөөд

GOBI	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЙНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-02
-------------	------------------------------------	--------------------------

илрүүлсэн тохиолдолд комплайнсын чиг үүрэг бүхий нэгжид нэн даруй мэдэгдэж, эрсдэлийг бууруулах, засах арга хэмжээ авна.

- 3.6.3 Байгууллагын бусад газар нэгж нь шинээр бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, түүнийг хөгжүүлэх, бизнесийн үйл ажиллагаа, харилцааг олон улсын түвшинд өргөтгөх зэрэг тохиолдолд НГ-аас санал, дүгнэлт авсан байна.
- 3.6.4 Байгууллага нь гадаад улсад франчайз үйл ажиллагаа явуулах, гадаад улсын байгууллагатай хамтран үйл ажиллагаа явуулах тохиолдолд НГ-аар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэргийн эрсдэл болон санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний эрсдэлийн талаар дүгнэлт гаргуулна.

4. КОМПЛАЙНСЫН БИЕ ДААСАН БАЙДАЛ

4.1 Бие даасан байдал:

- 4.1.1 ГЗ нь ТУЗ-с баталсан “Комплайнсын бодлого”-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах, хянах зорилгоор бие даасан, хараат бус, сонирхлын зөрчлөөс ангид, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх, үүрэг тодорхойлогдсон, хүний нөөц, бусад нөөц бололцоогоор бүрэн хангагдсан, мэргэшсэн, байнгын үйл ажиллагаатай НГ-ыг албан ёсоор байгуулан Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад ажиллуулна.
- 4.1.2 НГ нь байгууллагын бусад нэгжүүд өөрсдийн үйл ажиллагаанд комплайнсын эрсдэлийг хэрхэн үнэлж, үр дүнтэй удирдаж чадаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих бөгөөд зөрчил, дутагдал, эрсдэл бүхий нөхцөл байдал илрүүлсэн тохиолдолд нэн даруй засах чиглэлээр заавар, зөвлөмж өгч түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 4.1.3 НГ нь үйл ажиллагаа болон илрүүлсэн зөрчил, дутагдал, дотоод хяналт шалгалтын үр дүнгээ ГЗ-д чөлөөтэй танилцуулах эрхтэй бөгөөд шаардлагатай гэж үзвэл ТУЗ-д шууд танилцуулах эрхтэй байна.
- 4.1.4 НГ-ын ажилтан, удирдлагаар бизнесийн үйл ажиллагаатай холбоотой үүрэг давхар гүйцэтгүүлэхийг хориглоно.
- 4.1.5 НГ-ын ажилтан, удирдлага нь албан үүргээ гүйцэтгэх зорилгоор байгууллагын аль ч хэлтэс, нэгжийн ажилтантай өөрийн санаачилгаар харилцах, шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулан авах эрхтэй байна.

GOBI	ГОВЬ ХК-ИЙН КОМПЛАЙНСЫН БОДЛОГО	Дугаар: Б22-ТХХ-01-02
-------------	------------------------------------	--------------------------

4.1.6 НГ нь комплайнсын эрсдэл гарсан байж болзошгүй асуудлаар албаны дотоод шалгалт явуулах эрхтэй байх ба шаардлагатай тохиолдолд байгууллагын холбогдох нэгж, ажилтан болон байгууллагаас гадуурх мэргэжилтнээс нууцлал, аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр туслалцаа авч болно.

4.1.7 НГ-ын ажилтан, удирдлага нь албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай боловсрол, мэдлэг, туршлага, ур чадварыг эзэмшиэн, холбогдох хууль тогтоомжийн талаар ойлголттой мэргэжлийн албан хаагч байна.

5. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

5.1 Комплайнсын бодлогын үүрэг, хариуцлага

- 5.1.1 Байгууллага нь Комплайнсын удирдлагын тогтолцооны бодлогыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хянах, байнгын сайжруулах замаар комплайнсын шаардлага болон үүрэг амлалтын нийцлийг хангаж, ёс зүйн хэм хэмжээг мөрдөн комплайнсын эрсдэлийг бууруулна.
- 5.1.2 Менежментийн багийн гишүүд нь Комплайнсын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, комплайнсын шаардлага болон үүрэг амлалтыг нийцүүлэх ажлыг удирдан, ёс зүйн хэм хэмжээг үлгэрлэн хамт олноо манлайлан ажиллана.
- 5.1.3 Дунд шатны удирдлага нь Комплайнсын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, комплайнсын шаардлага болон үүрэг амлалтыг нийцүүлж, ёс зүйн зөв үлгэр дуурайлал үзүүлэн ажиллана.
- 5.1.4 Ажилтан нь Говь ХК-ын Ёс зүйн дүрэм, Комплайнсын бодлого болон бусад дүрэм, журам, заавар, зааварчилгааг чанд мөрдөн, ёс зүйн хэм хэмжээг баримтлан, зөрчлийг мэдсэн бол заавал мэдээлж ажиллана.

ТӨГСӨВ.